

5

ИНФЛЯЦИЙН ШИНЖИЛГЭЭ,
ДУГНЭЛТ, САНАЛ

Д.Цэрэнпил

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжих жилүүдийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн ерөнхий зорилт нь:

- эдийн засгийг ардчилах (төрийн өмчийг хувьчлах, үнэ, валют, эдийн засгийн гадаад харилцааг оролцуулан);
- хямралаас гаргаж эдийн засгийн макро түвшинд тогтворжилт (санхүү, төсөв, мөнгө-зээлийн тогтолцоог эрүүлжүүлэхээс эхлэн);
- зах зээлийн харилцаанд шилжих (хууль эрх зүй, эдийн засаг, нийгмийн) нөхцлийг бүрдүүлэх, үйл явцыг хурдасгах явдал байлаа.

Шилжилтийн эхний жилүүдэд ялангуяа 1991-1993 онд эдийн засаг, санхүүгийн гүнзгий хямралд орж санхүү, мөнгө-зээлийн чадавхи доройтож, үнэндээ аюулын ирмэгт тулж очсон. Урсгал төлбөр, дотоод гадаад өрийг төлөхөд улсын санхүүгийн чадвар хүрэлцэхгүй болсон хүнд үе байлаа.

1991-1993 онд Монголын эдийн засгийн гол үзүүлэлт

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	1991	1992	1993	1994
1	ДНБ-ий өсөлт (бууралт) %	-9.2	-9.5	-3.0	2.3
2	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт (бууралт) %	-13.1	-11.5	-10.6	2.7
3	ХАА-н бүтээгдэхүүний өсөлт (бууралт) %	-5.1	-4.0	-7.1	7.1
4	Инфляц %	52.7	325.5	183.0	66.3
5	Ажилгүйдэл (мянган хүн)	55.4	54.0	71.9	74.9

Эдийн засаг түргэн хурдацтай унаж, хүн амын амьдралын түвшин эрс доошилж, ажилгүйдэл, ядуурал бодит үзэгдэл болж, үнэ, валютын ханш огцом өсч, төгрөгийн худалдан авах чадвар доройтож, инфляци жолоодлогогүй хэмжээнд хүрч өссөн.

Хямралын нэг үр дагавар нь үнийн болон инфляцийн огцом өсөлт юм. Хэрэглээний үнийн ерөнхий индекс 1992 онд 4.3 дахин, 1993 онд 2.8 дахин тус тус өссөн.

Инфляци эдийн засгийн амьдралын байнгын хүчин зүйл болж, эдийн засгийн харилцааны ерөнхий тогтолцоонд ихээхэн төвөг учруулдаг. Инфляцийн түвшин түүний нөлөөллийн хэмжээнээс бүхэл нийгэм болон эдийн засаг шалтгаална. Практикт (үндсэндээ ХХ зууны хоёрдугаар хагсаас) инфляцийн хөгжлийг гурван үед хуваан үздэг:

- | | |
|-------------------|---|
| – мөлхөө (хэвийн) | жилд 3-5 хувь; |
| – цогио | жилд 30-100 хувь; |
| – жолоодлогогүй | жилд хэдэн зуу, мянган хувиар хэмжигддэг. |

Энэ бол ойролцоо, жишсэн хуваалт юм. Янз бүрийн орнуудад инфляцийн янз бүрийн түвшний үр дагавар харилцан адилгүй байдаг. Чухамдаа инфляцид зохицон дасах туршлагаас шалтгаална.

Инфляц эдийн засагт, ялангуяа манайх шиг жижиг эдийн засагт ихээхэн аюултай үзэгдэл. Эрдэмтдийн бүтээлд инфляцийн хор нөлөөний тухай янз бүрээр дүрслэн хэлсэн байдаг. Нобелийн шагналт эрдэмтэн М.Фридман "Адилхан мансуурал авахын тулд улам ихээр хүртээж байгаа мансууруулах бодисын нэгэн адил зүйл" гэсэн байхад өөр нэг эрдэмтэн бүтээлдээ "Мөнгөн хөрөнгийн эзэнд ногдуулсан нуугдмал гувчуур татвар" гэж тэмдэглэсэн байдаг. Мөн Английн ерөнхий сайд асан М.Тэтчер "Инфляц бол ялимгүй зүйл гэж үзэж болохгүй, мансууруулах бодистой адил аюултай зүйл" гэсэн байдаг.

Чухамдаа инфляц гэдэг нь мөнгөний нэгжийн худалдан авах чадвар буурч улмаар үнийн түвшин мэдэгдэхүйц хэмжээгээр үргэлжилсэн ужиг байдлаар өсөх явдал юм.

Өрсөлдөөний нөхцөлд инфляцийн чадавхийн нөлөөлөл нь эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн үнийн хэлбэлзлээр илэрнэ. Тийм хэлбэлзэл нь дээд доод хязгаартай бөгөөд манай орны нөхцөлд байраа солих явдал гарч байв.

Зах зээлийн үнийн дээд хязгаар нь нэг талаас таваарын чанараар, нөгөө талаас төлбөрийн чадвар бүхий эрэлтээр тодорхойлогдоно. Үнийн дээд хязгаар нь таваарын үйлдвэрлэлийн зардлаар-мөнгөн хэлбэрийг олсон материалын болон хөдөлмөрийн зардлаар нөхцөлдөнө.

Монголын эдийн засагт төлбөрийн чадвар бүхий эрэлтийн бууралт нь үйлдвэрлэлийн үйл явцын хэвийн эргэлтийг хангахгүй тийм үнийн түвшинг урьдчилан бүрдүүлсэн юм. Үүний үр дүнд нийлүүлэлтийн дарамт бүхий инфляц үүсэж байна. Энэ нь төлбөр тооцооны байнгын түгжрэл, дампуурал, монетарын хатуу хязгаарлалтын үед эдийн

засгийн уналт хүчтэй болох, түүнчлэн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт байнга буурах явдлаар илэрнэ.

Нийлүүлэлтийн дарамт бүхий инфляцийн нөлөөлөх масштаб нь Монголын нөхцөлд инфляцийн зардлын шинж давуутай байгаагаар тодорхойлогдоно. Зардлын ихсэлт инфляцийн өсөлтөд шууд нөлөөлж, тойруугаар нийт эдийн засгийн инфляцийн чадавхийг нэмэгдүүлнэ. Энэ тухай дараа тодорхой өгүүлэгдэнэ.

Инфляцийн талаар эрдэмтдийн дунд янз бүрийн үзэл бодол байдаг. Ерөнхийд нь авч үзвэл инфляцид нөлөөлөх хүчин зүйлийг:

1. монетар биш хүчин зүйл
2. монетар хүчин зүйл гэж хоёр ялгаж судлах нь зүйтэй.

Манай орны хувьд монетар биш хүчин зүйлийн гол шалтгаан нь:

- а. социалист эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа үед бүтцийн хүчин зүйлээс шалтгаалах бүтцийн инфляци;
- б. зардлын өсөлтөөс уламжилсан зардлын инфляци гэж ялган үзэж болно.

1. Монетар биш хүчин зүйлийн нөлөөлөл

Бүтцийн инфляц буюу шилжилтийн үеийн инфляци, үүний хүчин зүйл нь:

Нэгд, төвлөрсөн төлөвлөгөөт үеийн эдийн засгийн бүтэц зах зээлийн эдийн засагт гэрээслэгдэн үлдсэн. Энэ нь нэлээд удаан үргэлжилнэ. Үүнээс үүдэн үйлдвэрлэлийн уналт, хэрэглээний зүйлийн хомсдол, үнийн өсөлт гарлаа.

Хоёрт, үйлдвэрлэл зах зээлийн дангаараа ноёрхсон байдал. Ганц нэг том үйлдвэр зах зээл дээр ямарч өрсөлдөөнгүй дангаараа ноёрхсон бүтэцтэй байв. Энэ дангаараа ноёрхол нь зах зээлийн арилжааны хүрээнд дөнгөж оруутаа өндөржүүлсэн үнээр өөрийн бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг эхнээсээ олгосон. **Зардлын инфляц** манайд хүчтэй байв. Монголд 1990 онд үнийг гэнэт 2 дахин нэмэх, улмаар үнийн чөлөөлөлт нь гарааны нээлттэй инфляцид шилжих нөхцөл болсон. Үнэ чөлөөлөлтийн хэр хэмжээгээр инфляцийн боломжийг нээх явдал шалтгаална. Үнэ чөлөөлөгдсөн бүтээгдэхүүний хэмжээ хэдийчинээ өргөн байх тутам төдийчинээ инфляци нээлттэй хэлбэрээр илэрдэг. Манай орон хэрэглээний бүх хүрээг хамруулан үнэ, тарифыг чөлөөлсөн. Үнэ чөлөөлөлтийн гарааны их хүч нь юуны урьд Монголын эдийн засагт урьд нь хуримтлагдсан инфляцийн чадавхи-дотоод хүчин зүйлтэй холбоотой.

1991-1993 онд инфляцийн чадавхи нь гадаад хүчин зүйлээс тодорхой хэмжээгээр шалтгаалах боловч хамгийн гол нь цэвэр дотоодын гаралтай болохыг онцлон тэмдэглэе. Энэ жилүүдэд барааны айхтар хомсдолд орсон. Шууд пропорциональ хамааралтай барааны хомсдол хэдийчинээ их байна анхны нээлттэй инфляци төдийчинээ өндөр түвшинтэй байх ёстой. Шилжилтийн эхний жилүүдэд манай оронд

бий болсон бараа таваарын аюултай гэж үзэж болох хомсдол нь инфляцийн хүлээлтийг гүнзгийрүүлсэн. Үүний зэрэгцээ эдийн засагт далд инфляцийн дарамтыг хүчтэй болгосон. Инфляцийн хуримтлагдсан чадавхи өөрийн гарцыг эрдэг, эсрэг тохиолдолд эдийн засгийн хүнд байдалд оруулдаг нь манай орны байдлаас тодорхой.

Зардлын инфляц нь дараах хүчин зүйлээс хамааралтай.

Нэгд, Түүхий эдийн нөөц, эрчим хүчний хүчин зүйл. Энд дэлхийн зах зээлийн үнэтэй зэрэгцүүлсэн манай орны үнийн тухай яригдана. Манай орны эдийн засаг энэ талаар тэнцвэргүй байв. Юуны урьд түүхий эдийн нөөц, эрчим хүчний ашиглалтын дотоод үнэ дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн доогуур байлаа. Үнийн чөлөөлөлт түүхий эд, эрчим хүчний үнийг өндөрсгөн үүнээс уламжлан нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал, хэрэглээний зүйлийн зүйлийн үнэ нэлээд өссөн. Энэ нь инфляцид нөлөөлсөн.

Хоёрт, Эрэлтийн бүтцийн хүчин зүйл. Инфляцид болон зардал нэмэгдэхэд энэ хүчин зүйл нөлөөлсөн. Энэ тухай өмнө хөндөгдсөн болно.

Гуравт, Нэрлэсэн цалингийн хэмжээний хүчин зүйл. Юуны урьд хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн хэт өсөлт нь ажиллагсад нэрлэсэн цалингаа нэмэгдүүлэх эрмэлзлэл тэмцлийг бий болгосон. 1992-1995 онд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд өөрийн ажиллагчдын тоог нэг их хорогдуулахгүйгээр цалингийн тогтвортой байдлыг хадгалах эрмэлзлэлтэй байв. Цалинг зайлшгүй индексжүүлэх шаардлага тавигдсан. Энэ нь зардал нэмэгдэхэд нөлөөлөв. ААН-д зардлын өсөлт нь цаашдаа алдагдалтай ажиллахгүйн тулд өөрийн бүтээгдэхүүний үнийг нэмж нөхөхөөс өөр аргагүй байдалд хүргэв. Ийм механизм нь ерөнхийдөө хөдөлмөрийн бүтээмж, цалингийн динамик хоорондын тэнцвэрт харьцаанд суурь зөрчил гаргадаг.

Дөрөвт, Техник, технологийн хоцрогдлын хүчин зүйл. Инфляцийн үйл явц манай орны эдийн засагт олон үйлдвэрлэлд технологийн хоцрогдлыг хүчтэй болгосон. Хуучирч хоцрогдсон техник, технологи нь бүтээмжийг улам бууруулж, өрсөлдөх чадварыг доройтуулсан. Бүтээмж буурснаар үйлдвэрлэж байгаа нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг өндөржүүлнэ. Үүнийг нөхөхийн тулд өндөр үнэ шаардагдана.

Тавд, Аж ахуйн холбоо тасарсан хүчин зүйл. Дотоод, гадаадын түншүүдтэй харьцах харилцаа төвөгтэй болсон. Гааль, гадаад худалдааны үнэ тариф, ачаа тээврийн тариф өндөржих нь аж ахуйн холбооны ялангуяа гадаадын байдал дээр баримжаалж улам хүндрэв. Энэ нь бүх үйлдвэрлэлийн зардал, хэрэглээний зүйлийн үнэ өсөхөд нөлөөлсөн. Үүний улмаас инфляци зардлын өсөлтөөс шалтгаалах болов.

Зургаад, Инфляцийн хүлээлтийн хүчин зүйл. 90-ээд оны эхэнд Монголын эдийн засагт жинхэнэ нээлттэй инфляцийн нөхцөлд ирээдүйн инфляцийг шинжлэх ухааны үүднээс судлах, прогнолох явдлыг зайлшгүй захиалга болгосон.

2. Монетар хүчин зүйлийн нөлөөлөл

ДНБ-ний түвшин тогтвортой үед гүйлгээнд байгаа нийт мөнгөний эргэлт хурдасвал гүйлгээнд байгаа нийт мөнгөний өсөлт инфляцийг нэмэгдүүлнэ. Харин гүйлгээнд байгаа нийт мөнгөний хэмжээ тогтмол байхад инфляцийн нөлөөлөл бодит ДНБ-ний түвшинг бууруулах өөрийн эх үүсвэртэй байдаг.

Хэрэв нийт мөнгөний эргэлтийн хурд тогтмол хэмжигдэхүүн биш бол ердийн нөхцөлд инфляцийн гол шалтгаан болно.

Ийм нөхцөлд нийт мөнгөний эргэлтийн хурдацаас инфляцийн хурд шууд хамааралтай байдаг. Нийт мөнгөний нэмэгдэлтийн хурдтай инфляцийн хурд шууд пропорциональ, харин бодит ДНБ-ий түвшний бууралтын хурдтай урвуу пропорциональ гэж монетириетууд баталдаг.

Монголд гарсан инфляци нь төрөөс авч хэрэгжүүлсэн мөнгө-зээлийн бодлоготой яриангүй холбоотой. Эдийн засгийн хямрал гүнзгийрэхэд ялангуяа 1991-1994 онд мөнгө-зээлийн тогтолцоо гүнзгий хямралд орсон. Мөнгөний засаглалаар явуулж байгаа, бодит секторын хэрэгцээнээс нэлээд давсан, нуугдмал зээлийн эмиссийн үр дүнд гүйлгээнд нийт мөнгө эрс нэмэгдсэн. 1990 оныг хүртэл Монголын нутаг дэвсгэр дээр Монгол банк нь эмиссын цорын ганц төв байлаа. Энэхүү мөнгөний монопольчлол 1991 онд задарч банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжих эхлэл тавигдсан. 1991 оны сүүлч хүртэл инфляци гагцхүү мөнгөн гүйлгээтэй л холбоотой байв. Зах зээлийн харилцаанд шилжиж эхлэх босгон дээр төгрөгийн ханшийг 2 дахин нэмэгдүүлж, үнэ тэр хэмжээгээр өндөржсөн, улмаар үнийг чөлөөлсөн явдал хуримтлагдсан нийт мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх, өсөлтийг хурдасгах нөхцөл болсон. Үүний нөгөө талаар шинээр байгуулагдаж эхэлсэн арилжааны банкууд хувь нийлүүлэгч түнш олж авах, үйлчлүүлэгчдийг өөртөө татахын тулд эхний үед зээлийг хэт их олгосон. Дотоодын зээл 1992-1994 онд жил бүр 1.5-2 дахин өсч байв.

Мөнгөн гүйлгээ-инфляци үнэ чөлөөлсөний үр дагавар аажмаар зөөлөрсний дараа инфляцийн динамик нийт мөнгөний (M_2) динамиктай корреляцийн өндөр хамааралтай нь илэрч эхэлсэн. Үнийн динамик банкнаас явуулсан мөнгөний бодлогын монетари шинжийг агуулж байв. 1991-1994 онд төв банк мөнгөн гүйлгээг эрчимтэй нэмэгдүүлсэн явдал инфляцийг хамгийн өндөр түвшинд хүргэх нөхцөл болсон. Чухам энэ нөхцөлд нийт мөнгөний динамикаас инфляцийн динамик шууд шалтгаалах болов. Мөн валютын ханшны динамик, нийт мөнгөний динамикаас, түүнчлэн валютын ханшны өсөлт нь инфляцийн өсөлтөөс шалтгаалах болов.

Мөнгөн гүйлгээ зээлийн сүүлийн 12 жилийн динамик үзүүлэлтийг хүснэгт 2-т гаргаж харууллаа.

Мөнгө-зээлийн статистик үзүүлэлт

Хүснэгт 2

		1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Инфляци %		52.7	325.5	189.0	66.3	53.1	44.6	20.5	6	10.0	8.1	8.0	1.6
Нийт мөнгө M_2	Дүн (млрд.төг)	9.9	13.1	42.8	76.8	102.0	128.4	170.1	167.2	220.2	258.6	331.1	470.1
	Өсөлтийн хувь	-	132.3	328.7	179.4	132.8	125.9	132.5	0.96	131.7	117.5	127.9	141.9
	ДНБ эзлэх %	0.52	0.26	0.26	0.27	0.28	0.24	0.23	0.20	0.24	0.25	0.29	0.38
Нөөц мөнгө	Дүн (млрд.төг)	2.1	5.3	14.3	29.1	37.5	51.2	63.0	74.8	112.1	132.9	143.8	175.3
	Өсөлтийн хувь	-	252.4	269.8	203.1	128.9	136.5	123.0	118.7	149.9	118.6	108.2	121.9
	M_2 -т эзлэх %	21.2	40.5	33.4	37.9	36.8	39.9	37.0	44.7	50.9	51.3	43.4	37.3
Нийт мөнгөний үржүүлэгч		4.714	2.472	2.993	2.639	2.720	2.508	2.497	2.237	1.964	1.947	2.302	2.681
Банкнаас гадуурхи мөнгө	Дүн (млрд.төг)	1.7	1.9	8.7	18.8	25.6	41.7	49.8	56.4	87.3	100.9	109.2	120.8
	Өсөлтийн хувь	-	111.8	483.3	216.0	136.2	162.9	119.4	113.3	154.8	115.6	108.2	110.6
	M_2 -т эзлэх %	-	14.1	20.5	24.4	25.1	32.5	29.3	33.7	39.6	39.0	33.0	25.7
	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд эзлэх хувь	85.0	65.5	82.2	86.2	85.9	90.4	87.7	91.4	95.3	93.3	91.6	89.7
Дотоод олгосон зээл	Дүн (млрд.төг)	10.9	16.1	24.5	49.2	45.5	90.2	67.6	136.1	116.6	84.8	129.3	200.0
	Өсөлтийн хувь	-	147.7	152.2	200.8	0.92	198.2	0.75	201.3	0.85	0.72	152.5	154.3
Зээлийн өрийн үлдэгдэл	Дүн (млрд.төг)	-	19.1	31.6	52.8	62.7	64.8	50.4	85.6	77.5	66.8	135.1	231.4
	Өсөлтийн хувь	-	-	165.4	167.1	116.7	103.3	0.77	132.1	0.90	0.86	202.2	171.3
Валютын ханш	\$ ханш ₮	40	150	396.5	414.19	473.62	693.51	813.16	902.0	1072.37	1097.0	1102.0	1125
	Өсөлт %	-	375.0	264.0	104.4	114.4	146.4	117.3	110.9	118.9	102.3	100.4	102.1
Монгол банкны зээлийн хүү		-	-	120-300	72-284	72-150	72-109	45-50	28.2	17.7	12.2	9.7	11.1
Арилжааны банкны зээлийн хүү		-	-	182-222.5	122.1-136	92-110	71-125	64-71.0	34.2-45.8	36.5-38.8	25.8-34.7	22.2-41.4	35.5
Хадгаламжийн хүү		-	-	24-125	10-101.2	12-101.2	12-80.1	3.6-69.6	3.6-42.6	3-30.0	1.2-24	1.2-24	1.2-24

Эндээс инфляци болон мөнгө-зээлийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тооцож шинжилгээ дүгнэлт хийж болно.

Эгзэгтэй энэ нөхцөлд төв банкны мөнгөний хатуу бодлогод зайлшгүй шилжсэн. Үр дүн нь үнийн динамикд шууд л тусгалаа олсон. 1995 оноос нийт мөнгөний нэмэгдүүлэлтийг хязгаарлав. Энэ үеэс инфляцийн түвшин аажмаар буурсан.

Нийт мөнгөний болон инфляцийн динамик хоорондоо ихээхэн хамааралтай болох нь хүснэгт 2-д үзүүлсэн судалгаанаас тодорхой. Энэ хоёрын одоогийн корреляцийн коэффициент нь 0.6078 байна. Үүнээс үзэхэд энэ хоёр хувьсагч хүчтэй хамааралтай байна.

Ер нь мөнгөн гүйлгээг (нийт мөнгийг) эрэлтээс түрүүлүүлж түргэн хэт нэмэгдүүлвэл үнэ төдийчинээ хурдан өснө, түүнчлэн үндэсний валютын ханш унадаг зүй тогтолтой. 1992-1994 онд нийт мөнгөний хэмжээ 32.3 хувиас 3.3 дахин нэмэгдэхэд үнийн жилийн өсөлт 1.7-4.3 дахин байсан. Энэ хугацаанд ам доллартай харьцуулсан төгрөгийн ханш 3.8-2.6 дахин унасан. Тухайн онуудад инфляцийн түвшин 325, 183, 66 хувь байлаа. Эндээс үзэхэд нийт мөнгөний өсөлтийн хурд өндөр байхад үндэсний валютын ханш тогтвортой, инфляцийн хурд доогуур байх боломжгүй.

Инфляцийн өсөлт, улсын дотоод өрийн хэмжээний нэмэгдэлт, зээлийн өндөр хүүг хадгалах, эдийн засгийн долларжилтийн түвшин дээшлэхийн нэг гол үр дагавар нь мөнгөн гүйлгээний өсөлтийн хурдыг нэмэгдүүлэхтэй уялдуулан мөнгөний эрэлтийг бууруулдаг.

Монгол орны хувьд инфляцийн түвшин монетар биш хүчин зүйлийн нөлөөлөл ихтэй болохыг урд нь бид тэмдэглэсэн. Гэхдээ мөнгөн гүйлгээний хурдын өөрчлөлт, инфляцийн хурдын хооронд ихээхэн хамааралтай болох нь хүснэгт 2-оос харагдаж байна. Тухайлбал 1999 онд гүйлгээнд байгаа нийт мөнгө 30 гаруй хувиар өссөн. гэтэл инфляци урьд оныхоосоо даруй 4 пунктээр нэмэгдсэн байв. Энэ нь мөнгөн гүйлгээний өсөлтийн хурд нэмэгдэхэд инфляци өсдөг нь батлагдаж байна.

Мөнгөн гүйлгээний өсөлтийн хурдыг бууруулахтай инфляцийн түвшний доошлолт уялдаж байдаг. Ийнхүү инфляцийн түвшин хэдийчинээ өндөр бол мөнгөн гүйлгээний өсөлт төдийчинээ түргэн, тэрчлэн мөнгөний эрэлт төдийчинээ доогуур байна гэсэн дүгнэлт гарч байгаа юм. Чухамхүү цаг үе, хэрэгцээгээ нарийн тооцож мөнгөн гүйлгээний хурдыг зохистойгоор бууруулвал тэр нь үндэсний валютын эрэлт нэмэгдэж байгаагийн хамгийн найдвартай нэг шинж болох бөгөөд улсад санхүүгийн тогтворжилт эхэлснийг жинхэнээр нь харуулах баталгаа болно.

Үндэсний валютын эрэлтийн түвшинг илтгэх өөр нэг үзүүлэлт бол ДНБ-ий мөнгөжилтийн түвшин юм. Үүнийг нийт мөнгийг ДНБ-д харьцуулж гаргана. Энэ харьцаа манайд сүүлийн 12 жилд 23-29 хувийн хооронд байна. Ер нь санхүүгийн тогтворжилтод хүрч чадвал ДНБ-ий мөнгөжилтийн түвшин дээшлэнэ. 2002 онд 29 хувь болжээ. Манайд 1998 онд энэ үзүүлэлт хамгийн доогуур 20 хувь байсан. Сүүлийн жилүүдэд өсөж байна.

Нөөц мөнгө, банкнаас гадуурхи мөнгө-инфляци

Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд банкны нөөц мөнгөний нийт дүн нэмэгдэж харин мөнгөний үржүүлэгч буурах хандлагатай байна. Үүний гол шалтгаан нь нийт мөнгөний нийлүүлэлт өсөж байгаатай холбоотой. Нөөц мөнгөний нийлүүлэлт бол банкны системд эргэлдэж буй активын хөрвөх чадвар өндөртэй хэсэг юм. Нөөц мөнгө нь нийт мөнгөний (M_2) дүнд эзлэх хувь нь энэ 12 жилд 33-51 хувийн хооронд өрөнхийдөө өсөж байна. Мөнгөний үржүүлэгч нь 1993 онд 2.99 хувь байснаа 2002 онд 2.68 хувь болжээ. Манай оронд санхүү, мөнгөн гүйлгээний хүндрэлтэй байсан жилүүдэд мөнгөний үржүүлэгч тогтворгүй бүр буурч байв. Ялангуяа 1992-1994 онд болон, 1999-2000 онд 1.94 хувь болтлоо буурчээ. Нөөц мөнгөний үржүүлэгч тогтвортой байвал улс орны эдийн засагт харьцангуй сайн нөлөөтэй. Нөөц мөнгөний нийлүүлэлт, түүний үржүүлэгч бол мөнгөн гүйлгээний чухал үзүүлэлт бөгөөд инфляцид ихээхэн нөлөөтэй. Иймээс төв банк байнгын анхааралдаа байлгаж, зохицуулалт хийж, хяналт тавьж байдаг.

Нөөц мөнгө, түүний үржүүлэгчийн хувьсал өөрчлөлтийг хүснэгт 2-д харуулсан болно. Нөөц мөнгө нь банкнаас гадуурх мөнгө, банкуудын нөөцөөс бүрддэг. Инфляци, нөөц мөнгөний корреляцийн коэффициент 0.871 байгаа нь өндөр хамгаалалт болохыг

гэрчилнэ. Өөрөөр хэлбэл нөөц мөнгөний өсөлт хурдасвал инфляцийн түвшин өндөржихөд шууд нөлөөлнө. Банкнаас гадуурх мөнгө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа нь хоёр зүйлийг илтгэнэ:


- Хэрэв харьцаа өсөж байвал банкнаас гадуур иргэдийн гар дээр бэлэн мөнгөний урсгал үлдэгдэл нэмэгдэж буйг харуулна. Энэ нь эцсийн дүндээ үнийн өсөлтийн хөөрөгдөх бэлэн талбар болно.
- Харьцаа буурч байвал иргэд хадгаламж хэлбэрээр мөнгөө байршуулах сонирхол нэмэгдэж буйг илтгэнэ.

Банкнаас гадуурх мөнгөний өсөлт, нөөц мөнгийг нэмэгдүүлж улмаар үнэ өндөржих бэлэн байдалд оруулж, ингэснээр инфляцийн өсөлтийн нөхцлийг бэлтгэдэг.

Гүйлгээнд гарсан мөнгө эргэж орж ирэхгүй бол банкны тогтолцооны мөнгө өсгөх чадварт сөрөг нөлөө үзүүлнэ. Банкнаас гадуурх мөнгөний хэмжээ нь банкны мөнгөн гүйлгээ зээлийн үйлчилгээ хэр зэрэг найдвартайг илэрхийлнэ. Үнийн өсөлт өндөр, банкинд итгэх найдвар хангалтгүй үед банкнаас гадуурх мөнгө өсөж, инфляцийн түвшин дээшлэх магадлал их болно. Банкны тогтолцоонд хүндрэл гарч, банкууд дампуурч байсан 1993-1994 онд банкнаас гадуурх мөнгөний хэмжээ 2.1-4.8 дахин, 1998-1999 онд 1.5 дахин нэмэгдсэнэнэ хугацаанд инфляцийн түвшин өндөр байлаа. 1998-2000 онд нийт мөнгөнд (M_2) банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь 33-39 хувь болтлоо, инфляци 8-10 хувь болж өссөн байна. Одоогийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 90 хувь нь банкнаас гадуур гүйгдэж байна. Банкнаас гадуурх мөнгө, инфляцийн корреляцийн хамаарлын коэффициент 0.648 байгаа нь хоёр хувьсагч хүчтэй хамааралтайг харуулна.

Хүү, инфляцийн зэрэгцүүлэлт

График 1



Хүү ба инфляци нь хоорондоо тодорхой хамааралтай. Инфляци өсвөл хүү нэмэгддэг, харин буурвал хүү буурах ёстой.

Сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин эрс буурч, түүнийг дагаж Төв банк үнэт цаасны хүүг бараг 2 дахин бууруулсан байхад арилжааны банкуудын зээлийн хүү өндөр хэвээр, буурсанч өчүүхэн бага хэмжээгээр буурч байна. Банкны түргэн борлогдох үнэт цаасны хүү буурч байхад хадгаламж, зээлийн хүү буурах ёстой. Учир нь үнэт цаасны хүүнээс олох орлого буурч байгаа тул арилжааны банкууд хадгаламжийн хүүгийн зардлаа мөн бууруулах хэрэгтэй. Төв банкны ба арилжааны банкуудын зээлийн хүү болон хадгаламжийн хүүг хүснэгт 2-д динамикаар үзүүлэв. Инфляци сүүлийн жилд мэдэгдэхүйц буурлаа, гэтэл зээлийн хүү дорвитой буураагүй. Инфляци хүүгийн бууралтад хүчтэй нөлөөлнө.

Судалгаагаар тооцоо хийхэд инфляци банкны үнэт цаасны хүүгийн корреляцийн хамаарлын коэффициент 0.915, арилжааны банкны зээлийн хүүгийн хамаарлын коэффициент 0.971 байна. Эндээс үзэхэд инфляцийн бууралтыг дагуулж зээлийн хүүг доошлуулах нь эдийн засгийн бодит салбарууд ялангуяа аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхид эерэгээр нөлөөлөх болно.

Долларжилт, төгрөгийн ханш, инфляци

Үндэсний мөнгө (төгрөг)-ний ханш, долларжилт хоёр харилцан уялдаатай шалгаалцалтай. Үндэсний валютын тогтвортой байдал алдагдахад долларжилт нөлөөлнө. Мөн эргээд үндэсний валютын тогтвортой байдлаас ихээхэн шалтгаалдаг. Олон улсын валютын сан 1971 онд үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлын дараах гурван шалгуураар тодорхойлохыг санал болгосон.

Үүнд:

- Жилийн инфляци 20 хувиас хэтрэхгүй;
- Доллартай харьцуулсан номиналь ханшний жилийн сулралт 25 хувиас хэтрэхгүй;
- Гадаад валютыг худалдан авахад ямар нэгэн хориг саад тавихгүй байх нь.

Манай оронд одоогийн байдлаар энэ гурван шалгуур үндсэндээ хангагдаж төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байна. 1993 оны 6-р сараас манай долларын (ер нь гадаад валютын) хөвөх ханшийг хэрэглэх болсон. Цаг үеийн байдалтай уялдаж долларын ханш өсөж, буурдаг тохиолдол жилдээ хэд хэдэн удаа гардаг боловч тэр нь нөлөөтэй биш, ерөнхийдөө тогтворжсон гэж үзэж болно.

Гол нь долларын ханш өндөржвөл төгрөгийн ханш буурч эндээс инфляци өсөх магадлалтай. Манайд ерөнхийдөө долларжих үйл явц явагдаж харин сүүлийн жилд идэвхжих хандлагатай байна. Долларжилтыг хоёр төрлөөр авч үзнэ:

- Активын долларжилт
- Өрийн долларжилт.

**Долларжилт, ханш, инфляцийн зэрэгцүүлэлт
(1991-2000 он) (%)**

Хүснэгт 3

Он	Активын долларжилт (М2-т гадаад валютын эзлэх хувь) оны эцэст %	Өрийн долларжилт (нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь) оны эцэст %	Оны эцэст ам.долларын ханш (төгрөг)	Ханшийн өсөлт буюу төгрөгийн сулралт %	Инфляци %
1991	6.1		40.0	640.7	52.7
1992	7.5	2.2	150.0	275.0	325.5
1993	33.0	15.2	396.5	164.3	183.0
1994	19.5	14.9	414.1	4.4	66.3
1995	20.5	14.2	473.6	14.4	53.1
1996	22.5	16.4	693.5	46.4	44.6
1997	29.0	32.6	813.2	17.3	20.5
1998	23.8	46.7	902.0	10.9	6.0
1999	27.4	39.2	1072.4	18.9	10.0
2000	26.7	41.4	1097.0	2.3	8.1

Эндээс дараах байдал тодорхойлогдоно:

- Шилжилтйн эхэн үед үнэ чөлөөлөгдсөн, өсөлт нь хурц байв. Долларын ханш огцом өссөн, энэ байдал 1997 оныг хүртэл үргэлжилсэн. Инфляцийн түвшинд шууд нөлөөлж байв. Цаашид долларын ханш тогтворжих хандлагад орсон.
- Активын долларжилтоос үзвэл 1993 оноос хойш 19.5-33.0 хувийн хооронд хэлбэлзэж, 2000 оны байдлаар 27 хувь байгаа нь дунд зэргийн долларжилттай эдийн засагтай орнуудын бүлэгт багтана.
- Өрийн долларжилтийн түвшин өсөж байгаа, цаашдаа ч өсөх болов уу. 1997 он хүртэл 20 хувиас хэтрэхгүй байв. 2000 онд 41.4 хувь болтлоо өслөө. Үүнийг гадаад зээлийн болон импортын өсөлт, гадаад худалдааны тэнцлийн алдагдалтай холбон үзэж болно.

1991-2002 оны төгрөг, ам долларын ханшны өөрчлөлт болон жилийн инфляцийн хоорондын корреляц хамаарлыг тооцож үзэхэд 0.679 байгаа нь өндөр хамааралтай гэж үзэж болно.

Энд нэг асуудлыг зориуд хөндөж хэлье.

Гадаад худалдааны түнш орнуудын инфляцийн түвшин, валютын ханш Монголын эдийн засагт үлэмж нөлөөтэй.

Төгрөг нэрлэсэн ханштайгаас гадна түүний бодит үйлчилж буй ханшны Монголын гадаад өрсөлдөх чадварыг илэрхийлж чадах үзүүлэлт юм. Төгрөгийн нэрлэсэн ханш огт өөрчлөгдөөгүй байсан ч Монголын бүтээгдэхүүний харилцан өрсөлдөх чадвар худалдааны түнш орнуудын үнийн хэлбэлзлээс болж өөрчлөгддөг. Энэ бол бодит

ханш үйлчилж байгаа нь тэр.

Манай орны гадаад худалдаанд томоохон жин эзэлж буй түнш орнууд (хойт (33), урд хөрш (31), АНУ (9) нийт 70 гаруй хувийг бүрдүүлдэг) төгрөгийн ханшид илүүтэйгээр нөлөөлнө. Судалгаанаас үзэхэд төгрөгийн бодит ханш сүүлийн жилүүдэд чангарах хандлагатай байна.

Дотоодын хэрэглээний үнийн индексийн өсөлт нь төгрөгийн ханшийн чангаралтыг тодорхойлж байна. Төгрөгийн нэрлэсэн ханш харьцангуй тогтвортой байгаа тохиолдолд дотоодын болон гадаадын түнш орнуудын хоорондох үнийн ялгаа нэмэгдэж байгаа нь төгрөгийн ханш улам чангарах үндэс болж байна. Энэ нь манай улсын гадаад худалдааны тэнцэл тогтмол алдагдалтай байх үндэс болж байна. Өөрөөр хэлбэл, экспортыг урамшуулахгүй, импорт өсч байна. Цаашид энэ асуудалд Монгол банк, гадаад худалдааны байгууллагын зүгээс анхаарч девальвацийн чиглэлтэй арга хэмжээ авах нь зохистой байх болно.

Улсын төсвийн алдагдал, инфляци

Инфляци эцсийн дүндээ эдийн засгийн макро, микро түвшинд санхүүгийн доройтолд нөлөөлнө. Үнэ өндөржихийн хэрээр үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж, мөнгөн орлого, ашгийн хэмжээ буурна. Энэ нь улсын төсвийн орлого хомсдох, зарлага нэмэгдэх, алдагдал ихсэх байдалд хүргэнэ.

**Монгол улсын төсвийн орлого, зарлагын
1991-2002 оны үзүүлэлт**

Хүснэгт 4

Он	Төсвийн орлого		Төсвийн зарлага		Төсвийн алдагдал		ДНБ-д эзлэх хувь		
	дүн (млрд.төг)	өсөлт %	дүн (млрд.төг)	өсөлт %	дүн (тэрбум.төг)	өсөлт %	орлого	зарлага	алдагдал
1991	6.5	100	8.9	100	-2.4	100	34.4	47.1	12.7
1992	11.9	183.1	11.6	130.3	0.4	-	25.2	24.5	-
1993	54.8	460.5	61.7	531.9	-6.8	170	32.9	37.1	4.1
1994	86.1	157.1	101.3	164.2	-15.2	223.5	30.4	35.8	5.4
1995	144.6	167.9	149.3	147.4	-4.7	0.31	36.9	38.2	1.2
1996	162.9	112.6	211.3	141.5	-48.4	1029.7	30.6	39.7	9.1
1997	222.5	136.6	287.6	136.1	-65.1	134.5	30.2	39.0	8.8
1998	239.9	107.8	342.1	118.9	-102.2	156.9	29.3	41.9	12.5
1999	266.5	111.1	364.7	106.6	-98.2	0.96	28.8	39.4	10.6
2000	351.1	131.7	429.7	117.8	-78.6	0.80	33.6	41.1	7.5
2001	424.5	120.9	470.1	109.4	-45.6	0.58	36.7	40.6	4.0
2002	466.5	109.9	536.5	114.1	-70.0	153.5	37.9	43.6	5.6

1991-1994 онд инфляци өндөр байх үед төсвийн орлогын өсөлтөөс зарлагын өсөлт түрүүлж алдагдал нь 1.7-2.2 дахин нэмэгдэж байлаа. 1995-1999 онд төсвийн зарлага, орлогоосоо харьцангуй түрүүлэн өсөж алдагдлын хэмжээ ихсэж, зарим жилд (1996 онд) 10 дахин нэмэгдэж, ДНБ-нд 9-12 хувийг эзлэх болсон.

Төсвийн алдагдлыг мөнгөжүүлэх-мөнгөний хэрэгслийн эмиссээр түүнийг санхүүжүүлэх нь нийт мөнгөний өсөлтийн хурдыг өндөр түвшинд байлгах нэг гол эх үүсвэр. Төсвийн алдагдал буурахад нийт мөнгөний өсөлтийн хурд буурна. Хэрэв төсвийн алдагдлын хэмжээ их байвал төдийчинээ нийт мөнгөний болон инфляцийн өсөлтийн хурд өндөр байна.

Тэгэхдээ Монгол улс төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд мөнгөний эмиссийн аргыг ердөө хэрэглээгүй юм.

Манай орон гадаад эх үүсвэрийг шүтдэг, өргөн ашигладаг. Гэхдээ гадаад зээлийн эх үүсвэрийг ашиглах үед улсын гадаад өрийн хэмжээ аяндаа нэмэгдэнэ. Энэ тохиолдолд санхүүгийн тогтворжилтод хүрч богино хугацааны асуудлыг шийдвэрлэсний үнэ цэнэ нь гадаад өрийг төлөхөд зориулагдах улсын төсвийн зарлагыг нэмэгдүүлэх гадаад төлбөрийн чадварын дунд ба урт хугацааны хурц асуудлыг үүсгэнэ.

Төсвийн алдагдлыг нөхөх эмиссын биш эх үүсвэр бол Засгийн газрын үнэт цаасыг гаргаж, борлуулах байршуулах үндсэн дээр дотоодын санхүүгийн нөөцийг ашиглах явдал юм. Харин инфляцийг өндөр хүлэлттэй бол санхүүгийн зах зээл дээр нэрлэсэн ба бодит хүүгийн хэмжээ өндөр хэвээр байдаг. Энэ нь нэг талаас нэрлэсэн ба бодит илэрхийллээр түүний өсөлтийг хурдасгаж улсын дотоод өрийн үйлчлэлийн үнэ цэнийг өндөрсгөж Засгийн газарт нэмэгдэл дарамт болдог, нөгөө талаас зээлдэгчдэд зээлийн нөөцийг үнэд оруулж, ингэснээр бодит үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтад садаа болно. Үүний зэрэгцээ улсын дотоод өр түргэн нэмэгдсэний үр дүнд эдийн засаг хурцадмал үе шатаас өсөлтийн шатанд шилжих явдлыг удаашруулна. Энэ тохиолдолд мөн гадаад өр нэмэгдэхтэй адил богино хугацааны асуудлыг шийдвэрлэх үнэ цэнэ нь дунд ба урт хугацааны төвтэй асуудлыг бий болгож, улам хурцатгана.

Дүгнэлт хийхэд шилжилтийн үеийн Монгол улсын эдийн засагт гарсан нэг эгзэгтэй асуудал болох инфляцийг гол хүчин зүйлүүд, нөлөөлөлөөр нь авч үзлээ.

Ажиглалт хийгээд байхад Монголын инфляцийн түвшин нь урдах эдийн засгаас үүдэлтэй "дэвсгэр"-ийн гэж үзэж болох талтай. Шилжилтийн үеийн эдийн засагт инфляцийг түргэн дарах үйл явцад өмнөх аж ахуйн тогтолцооноос уламжлагдсан түүний бүтэц зохих хэмжээгээр саад учруулж болно.

Эдийн Засгийн бүтцийг зохион байгуулалтын өөрчлөлт боловсронгуй биш үед инфляцийг мэдэгдэхүйц бууруулах явдал нь түр зуурын гэж үздэг. Эдийн засгийн зохицолдоогүй бүтэц нь цаашдаа инфляцийн шинэ давалгаа үүсэх бэлэн дэвсгэр болно. Зөвхөн гүнзгий өөрчлөн байгуулалтыг (өмч хувьчлах, монополь байдлыг устгах) хийж, хувийн секторыг эрчимтэй хөгжүүлэх үед л инфляцийг бүрэн арилгахад

амжилт олж болно. Харин энэ өөрчлөлтийг Монголд нэлээд амжилттай үр дүнтэй хийгдсэн гэж үзэж болно. Энэ нь инфляци түргэн буурах нэг нөхцөл болсон.

Ашигласан ном, хэвлэл

1. Аткинсон Э.Б, Стиглиц Д.Э, Лекции по экономической теории государственного сектора. М.: Аспект-Пресс, 1995
2. Р.Белоусов, А.Белоусов, Инфляция: факторы, механизм, стратегия преодоления. Экономист, 1996, №2
3. А.Илларионов. Финансовая стабилизация в республиках бывшего СССР. Вопросы экономики, 1996, №2
4. Курс экономики (Под ред. Б.А.Райзберга). М.: Инфра-М, 2000
5. С.В.Лаптев, Ф.В.Филина. Основы теории государственных финансов. М.: Юрист, 2001
6. С.Лушин. Проблема инфляции. Экономист, 1999, №2
7. В.Майский. Экономический рост, инфляция и мировая статистика, Вопросы экономики, 1996, №10
8. Монгол банк судалгааны ажил. УБ., 2002
9. Д.В.Орусов. Факторный анализ причин инфляционного процесса в Российской Экономике. Финансы и кредит, 2000, №3
10. Э.Райхмин. Основы экономической теории: безработица и инфляция. М.:Наука 1998
11. Д.Ю.Стиглиц. Экономика государственного сектора. М.: МГУ; Инфра-М, 1997
12. Теория переходной экономики (под ред. В.Николаевой). М.: 2001
13. Экономическая теория на пороге XXI века. М.: Юрист, 2001
14. Монгол улсын төсвийн орлого, зарлагын 1991-2002 оны үзүүлэлт